

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

**“ХЭНТИЙ НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨҮГ-
ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Цадингийн зардлын талаар3

Асуудал 2

Цалингийн зардлын талаар.....4

Асуудал 3

Авлагын талаар 5

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийтлэг үйлчилгээний газарт зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийтлэг үйлчилгээний газрын захирал, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

1. Ажилласан цагийн бүртгэл байхгүй, бүрдэл дутуу баримтаар 1 ажилтанд нийт 5362.3 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн " 13.1-ийн "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-ын" Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг мөрдөөгүй,

2. Бичиг хэргийн ажил хавсарсан нэмэгдэлд 1899.7 мянган төгрөгийг олгож, төсвийн хөрөнгийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхээр төлөвлөж зарцуулах", 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсадын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчиж эдгээр нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Эрсдэлүүд

Анхан шатны бүрдэл баримтаар гүйлгээ хийсэн эсэх, хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

ААГ-ын зөвлөмж

1. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийдэг зөрчлийг давтан гаргахгүй байх
2. Ажиллагсдад ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн цалин олгож байх
3. Бичиг хэргийн ажил хавсарсан нэмэгдлийг зогсоож, ажлын байрны тодорхойлолтод тусгаж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

ААГ-ын ажиглалт

1. Санхүүгийн тайланд тусгагдсан насжилт өндөртэй 2.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиглаагүй, үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6.”Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтуудыг зөрчиж, Үнэн зөв байдал “ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ААГ-ын зөвлөмж

1. Санхүүгийн тайланд тусгагдсан насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллан, авлагыг бүрэн барагдуулах
2. Цаашид санхүүгийн тайланд тусгагдсан авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулж байх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх

Төсвийн захирагчийн хариу

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.ЭРДЭНЭБААТАР
Д.ОЮУНТУЯА



БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

2317144297
СИДА0046 9074082